

УЛАМЖЛАЛТ ШАГАЙН ТОГЛООМ НААДГАЙН ТӨРЛИЙГ ИЛЭРХИЙЛЭХ
СУДАЛГААНЫ ЗАРИМ ҮР ДҮНГЭЭС

(Хархорин сумын жишээн дээр)

А.Ханджав¹ Ч.Догсом², Ж.Батсуурь³

handaa.adiya@yahoo.com, Dogsom2829@gmail.com, J.Batsuuri@yahoo.com

Удиртгал

Монголчууд түүхэн урт хугацааны туршид маш олон төрлийн тоглоом наадгай зохион бүтээж, түүгээрээ тоглон наадаж, хүүхэд багчууддаа зааж сурган, өнөөг хүртэл өвлүүлэн ирсэн билээ. Монголчуудын тоглоом наадгайн дотор ясан тоглоом чухал байр суурийг эзэлж байсан. Үүнд чөмөг татах, сээр чичих, цохих, дал шавдах, өвчүү цохих, толгой хаях, таваг цохих мөн далны яс, үхрийн годон сүүлний ясаар мэргэлэх зэрэг төрөл бүрийн үйлдэл, арга хэлбэр, дүрэм журам бүхий наадгай байсны дээр шагайн наадгай гол ноён нуруу нь байжээ. [С.Бадамхатан. 2012. т167.]

Монгол Улсын хэмжээнд шагай наадгайн 60 гаруй төрлөөр тоглож болдог ба төв Халх буюу Дэлхийн өв-Орхоны хөндийн соёлын дурсгалт газарт 30 гаруй төрөл нь дэлгэрсэн байдаг хэмээн тэмдэглэгдсэн байна. [Б.Дамбийням.1963.] шайгай наадгайгаар няслах, сум шүүрэх, алаг мэлхий өрөх, андрайцах, морь уралдуулах, цагаан тэмээлцэх, тэмээ ботоглуулах зэрэг маш олон төрөл буй.

Дэлхийн Өв-Орхоны Хөндийн Соёлын Дурсгалт Газар нь ЮНЕСКО-гийн Дэлхийн өвийн Хорооноос Дэлхийн соёлын болон байгалийн өвийг хамгаалах тухай конвенцийн II,III дугаар шалгуур нь нүүдлийн соёлын өвийг өнөөг хүртэл хадгалан өвлүүлэн ирсэн өлгий нутаг хэмээн 2004 онд дэлхийн өвд бүртгэгдсэн билээ.

Тиймээс шагайн наадгай тоглоом нь нүүдлийн соёлын оюуны үнэт өв болохын сацуу, тухай улсын ёс заншил, зан үйл, утга бэлэгдэл, аман зохиолын төрөл болох оньсого, ерөөл зэргийг өөртөө агуулсан соёлын биет бус өв юм. Иймд уламжлалт шагайн наадгайн төрлийг илрүүлэх судалгааг Хархорин сумын иргэдээс түүврийн

¹ Дэлхийн өв-Орхоны хөндийн соёлын дурсгалт газрын хамгаалалтын захиргааны мэргэжилтэн

² ДӨ-ОХСДГ-ын хамгаалалтын захиргааны менежер, соёл судлалын докторант

³ Шинжлэх ухааны гавъяат зүтгэлтэн, доктор(Sc.D), профессор

аргаар авч, үр дүнг тооцох, цаашид зааж сургах, өвлүүлэх ажлын санал зөвлөмжийг тодорхойлохыг зорилоо.

Судалгааны ач холбогдол

ДӨ-ОХСДГ-ын нутагт уламжлалт шагай наадгайг төрлүүдийг сэргээн хөгжүүлэх, уламжлуулахад шаардлагатай мэдээллийн сан бий болох

Судалгааны ажлын зарим үр дүн


Шагайн наадгай тоглоомын төрлийн илрэл

Шагай.

Малын хойд хөлийн шаантны нарийн үзүүрт, нөгөө талаараа борви ясны өргөн талд холбогдон орших жижиг цул ясыг шагай гэнэ. бог(хонь,ямаа), бод(үхэр) малын шагай гэж ангилдаг. Шагайг буух байдлаар нь өөр өөрөөр нэрлэх бөгөөд үүнд: бөгтрөөр дээш харж унавал хонь, хонхор нь дээш чиглэн унавал ямаа, тахираар дээш харвал тэмээ, шулуун матигар үзүүр хэсгээр буувал морь, харин хоёр зэтгэр үзүүр нь доош харж, бөөрөнхий нь дээш чиглэн буувал онх гэж нэрлэж иржээ.

Шагайгаар наадах нь түргэн бодож сэтгэх, хараа сайжирах, хүндлэх, авхаалж самбаа хурд нэмэгдэх, гар хурууны эв дүйг хөгжүүлэх зэрэг маш олон эерэг чанаруудыг хүүхэдэд суулгаж өгдөг сурган хүмүүжүүлэх ач холбогдолтой тоглоом юм. [Монгол нүүдэлчдийн тайлбар толь. I боть. 2014.]

Бид Дэлхийн өв-Орхоны хөндийн соёлын дурсгалт газрыг төлөөлж буй хүн ам төвлөрсөн, аялагч жуулчид зорин ирдэг, түүхэн газар нутгийг илтгэдэг Хархорин сум дахь шагайн наадгайн тоглоомын төрлийн өнөөгийн байдлыг тогтоох, түүнийг тоглох арга хэлбэр, тоглоомтой холбоотой хэрэглэгдэхүүн, түүнийг сэргээх боломжийг судалж үзэхээр тусгай санал асуулга боловсруулан Өвөрхангай аймгийн Хархорин сумын иргэдээс түүврийн аргаар судалж үзэхэд шагайн наадгайн 30 гаруй төрлөөс 20 төрөл нь энэ нутагт илэрч байна. Эдгээр төрлөөс хамгийн сайн мэддэг буюу түгээмэл хэрэглэж байгаа нь шагай няслах, морь уралдуулах, шүүрэх, алаг мэлхий өрөх, дөрван бэрх орхих, хамгийн бага буюу мартагдаж байгаа нь өрөг харвах, таван хошуу мал өрөх, мянгадах, гүү саах, тэмээ сөгдүүлэх арга хэлбэрүүд илэрч байгаа нь доорх зургаас тодорхой харагдаж байна(Зураг 1).



Зураг 1. шагайн наадгайн төрлийн илрэл

Түгээмэл хэрэглэгдэж байгаа төрөл: төрөл тус бүрээр нь авч үзэхэд шагай няслах(17.2%), морь уралдуулах(16.4%), шагай шүүрэх (15.7%), алаг мэлхий өрөх(14.9%), дөрвөн бэрх(12.7%), шагай таах(8.8%) зэрэг байна. Харин эдгээрийн нийлбэрийг авч үзэхэд 85.7 хувь буюу хамгийн өндөр үзүүлэлтэй байгаа нь магадгүй эдгээр төрөл нь тоглоход амар хялбар, сонирхолтой, нөгөөтэйгүүр таван хошуу малаа хайрлах, морио дээдлэн хүндэтгэх үзэлтэй холбоотой байж болох талтай. Мөн ахмад үеийнхэн маань өв соёлоо дээдлэн хүндэтгэж өнөөг хүртэл өвлүүлэн хөгжүүлж байгаа нь тодорхой байна.


- Өвөө, эмээ 45.5%
- Аав, ээж 37.7%
- Нагац ах,эгч нараас 7.4 %
- Найз нөхдөөс 3.0%
- Танил хүнээс 1.3% үүнээс үзэхэд зөвхөн гэр бүлийн нөхцөлд, орчноосоо сурч ирсэн энэ уламжлалыг цааш дэлгэрүүлэх боломж байгаа нь харагдаж байна.

Хэрэглээ нь цөөрч буй төрөл: Дундаж үзүүлэлтэй төрөл тус бүрийг үзэхэд шагайн харваа(2.9%), цагаан тэмээцэх(2.4%), шагай тулах(2.1%), бөгж нийлүүлэх(2.1%), мөсөн шагай(1.9%), шагай сэлгэх/андрайцах/(1.6%) зэрэг байна. Эдгээрийн нийлбэрээс хархад 13% -ийн үзүүлэлттэй байна.

Мартагдаж буй төрөл: энэ төрөлд тэмээ сөгдүүлэх (0.1%), гүү саах (0.1%), мянгдах (0.1%), таван хошуу мал өрөх (0.1%), эрэг харвах (0.1%) зэрэг байна. Үүний нийлбэр нь 1.3% буюу хамгийн бага хувийг эзлэж байна. энэ нь орчин цагийн нийгмийн хөгжил, техник, технологийн дэвшилтэй шууд болон шууд бусаар хамааралтай билээ. Шагайгаар тоглох арга ухаан, хэрэглээний байдлыг авч үзэхэд:

- Мартагдаж байна. 43%
- Төрөл нь цөөрч байна. 37%-
- Мэдэхгүй 20% гэж хариулсан байна.

Уламжлалт шагай наадгай тоглоомын цөөрч, мартагдсан төрлийг гэр бүл, залуу үеийнхэнд түгээн дэлгэрүүлэхийн тулд ямар үйл ажиллагаа зохион явуулах тал дээр санал авч үзэхэд(зураг2)



Зураг2 Судалгаанд хамрагдсан иргэдийн санал

Энэхүү зургаас хархад эцэг, эх суралцаж, хүүхэддээ зааж өгөх(25.0%) хамгийн өндөр үзүүлэлтэй байна. Энэ бол эцэг, эхээр дамжуулан гэр бүл буюу тухайн орчинд нь өвлүүлэх боломж байгааг илтгэн харуулж байна.

Шаггайн тоглоомын хэрэглэгдэхүүний нэршил.

Шагайн наадгайгаар тоглохтой холбоотой түүнийг дагалдах хэрэглэгдэхүүнийг хэрэглэх, нэрлэх уламжлалын өнөөгийн байдлыг тодруулахад хөө хуяг, хөм, ширмэл ширдэг, шагалцах(няслах, шүүрэх), зэргийг 70-с дээш насныхан илүү(... %) мэдэж байна. Харин залуучууд(10-40 насныхан) орчин цагийн хэллэгээр сум, шоо, хивс зэргээр нэрлэж байлаа. Энэ нь хуучны соёл, уламжлалын нэршил цаг үеэ даган өөрчлөгдөж байгааг илтгэж байна. (Зураг3)




Зураг 3 шагай наадгайн хэрэгслийн нэршил

Зурагт3 сум(28,0%), шоо (21.5%) өндөр үзүүлэлттэй байна. Энэ нь цагаан сарын баярын үеэр айл бүр алаг мэлхий өрж, шүүрч тоглодогтой холбоотой эдгээр нэршил өргөн хэрэглэж байж болно.

Шагайн наадгай тоглоомын хэрэглээний өнөөгийн байдал

Уламжлалт шагайн тоглоомын өнөөгийн хэрэглээний байдлыг насны ангиллаар авч үзэхэд шагай няслах, шүүрэх, төрөл буюу арга хэлбэрээр тоглож байгаа нь хүүхэд, залуусын дунд өргөн хэрэглэгдэж буй нь судалгаанаас харагдаж байна.



Зураг 4 шагайн наадгайн төрлүүдийг хэрэглэж буй иргэдийн насны бүлэг

Зураг4 үзэхэд 10-24 (24.6%) үзүүлэлттэй байна. Энэ нь хүүхэд, залуучууд аав, ээж, өвөө, эмээгээс өвлөн хөгжүүлж байгаа нь харагдаж байна. 25-44(21.1%), 45-

60(18.5%) бага зэрэг буурсан үзүүлэлттэй байна. 61-75(19.3%) насныхан өндөр үзүүлэлттэй байгаа нь энэ насны хүмүүсийн өссөн цаг үетэй шууд холбоотой байж болох юм.

ДҮГНЭЛТ

Дэлхийн өв-Орхоны Хөндийн Соёлын Дурсгалт Газар дахь уламжлалт шагайн тоглоомын төрөл, түүний өнөөгийн хэрэглээний байдлыг судлаж дараах дүгнэлтэд хүрч байна. Үүнд:

1. Судалгаанаас үзэхэд 20 төрөл илэрсэн бөгөөд үүнээс хамгийн бага буюу 0.1-0.4 хувийн үзүүлэлттэй нь мянгадах, гүү саах, тэмээ сөгдүүлэх төрлүүд илэрч байна.Бага үзүүлэлттэйгээр илэрсэн төрлийг сэргээх, хүүхэд залуучуудад зааж сургах боломжтой арга хэмжээг олон талт хэлбэрээр зохион байгуулах, мөн гэр бүлийн хүрээнд буюу тухайн орчинд нь өвлүүлэх боломж байгаа нь судалгаанаас харагдаж байан.
2. Шагайн тоглоомын төрөл, түүнийг хэрэглэж буй хүмүүсийг насны бүлгээр авч үзэхэд хүүхэд, залуус голдуу морь уралдуудах, няслах, шүүрэх төрлийг элбэг хэрэглэж байгаа судалгаагаар тогтоогдож байна. Энэ нь шагайн тоглоомын бусад төрлийг сайн мэдэхгүй, тоглохгүйн улмаас ерөнхийдөө мартагдаж байгаа нь илэрхий байна.
3. Шагайн наадгайн төрөл цөөрч байгаа хэдий ч ахмад үе эдгээр олон төрлийг мэдэж байгаа нь хүүхэд залуучуудад мартагдсан төрлийг сэргээхэд олон талт арга хэлбэрүүдээр сэргээн хөгжүүлэх боломж байгаа нь тодорхой харагдаж байна.

Зөвлөмж :

Сургуулийн өмнөх болон бага ангийн сурагчдад булан бий болгох

Музей, орн нутаг судлах танхимд тоглоом наадгай тэр дундаа нүүдлийн соёлтой холбогдох шагайн наадгайгаар тоглох танхим бий болгох боломжийг эрэлхийлэх Сум орон нутгийн онцлогт тулгуурлан тоглоом наадгайн ач холбогдлыг таниулах үйл ажиллагааг олон талт хэлбэрээр зохион байгуулах бөгөөд холбогдох хүмүүстэй хамтран ажиллах

АШИГЛАСАН НОМ ЗОХИОЛ

1. Бадамхатан С., 2012. Монгол Улсын угсаатны зүй. I бот. УБ.
2. Дамбийням Б., 1963. Шагай. Цэцэрлэг хот.
3. Очир А., Наранбаатар Д., 2015. Дэлхийн Өв-Орхоны хөндийн соёлдын дурсгалт газрын 10 жил, өнгөрсөн бө ирээдүй. УБ.
4. Очир А., Мацукава Т., 2018. Орхоны хөндийн өв. Сэтгүүл дугаар 5. УБ.
5. Саруул Э., 2016. Соёлын өв судлал. УБ. т 49, 72,73,74
6. Сүхбаатар Д., 2018. Музей судлал. УБ.
7. Сүлд-Эрдэнэ Г., 2014. Монгол нүүдэлчдийн тайлбар толь. I бот. УБ. т18
8. Чимиддорж Н., 2017. Дэлхийн Өв-Орхоны хөндийн соёлын дурсгалт газар дахь аялал жуулчлал. УБ.
9. Энхбат Г., 2018. Соёлын биет бус өвийн их наадам-2018. УБ. т 45

